АЖЛЫН ДААЛГАВАР

Монгол Улс: Ухаалаг засаг төсөл

Санхүүжилтийн хэлэлцээр: 5483-MN

Ажлын нэр: Гадаадын хөрөнгө оруулалтын “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн систем хөгжүүлэлтийн ажлын даалгавар боловсруулах зөвлөх үйлчилгээ

Бүртгэлийн дугаар: 2.5.4

1. Ерөнхий зүйл

Монгол Улсын Засгийн газар Дэлхийн банкны санхүүжилтээр мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглан төрийн үйлчилгээний хүртээмж, ил тод байдал, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр “Ухаалаг засаг” төслийг хэрэгжүүлж байна. Уг төслийн санхүүжилтийн зарим хэсгийг Гадаадын хөрөнгө оруулалтын “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн систем хөгжүүлэлтийн ажлын даалгавар боловсруулах зөвлөх үйлчилгээнд зарцуулахаар төлөвлөж байна.

“Нэг цэгийн үйлчилгээний төвийн систем” нь Хөрөнгө оруулагчдад шаардлагатай үйлчилгээ, зөвлөгөө, мэдээллийг нэгдсэн нэг платформоос үзүүлнэ. Уг системд Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйлчилгээ, Хөрөнгө оруулагчдын гомдлыг барагдуулах механизм, Гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой статистик мэдээ, Хөрөнгө оруулалт эрэлхийлсэн төслийн мэдээлллийн сан гэсэн 4 дэд систем багтана.

Бид энэ зөвлөх үйлчилгээний хүрээнд системийг загварчлах, нэгдсэн платформ болон дэд системүүдийн хөгжүүлэлтийн ажлын даалгаврыг боловсруулах зөвлөхийг хайж байна.

2. Системийн хамрах хүрээ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын компанийн бүртгэлтэй холбоотой үйлчилгээ, Гадаадын иргэн, харьяатын газрын виз, оршин суухтай холбоотой үйлчилгээ, Татвар болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын татвар, даатгалын үйлчилгээтэй холбоотой үйлчилгээнүүдийн өргөдлийг нэгтгэн цахим нэг өргөдөл болгох, төрд байгаа лавлагаа, мэдээлэл, тодорхойлолтыг төрийн байгууллагууд хоорондоо шууд солилцдог болно.

Хөрөнгө оруулагч аль байгууллагад гомдсоноос үл хамаарч SIRM /Хөрөнгө оруулагчдын гомдлыг барагдуулах цахим механизм/-д гомдол гаргана. SIRM-д төрийн бүх байгууллагууд холбогдсон байх бөгөөд хөрөнгө оруулагчийн гомдлыг цахимаар шилжүүлэн дүгнэлт гаргаж, шийдвэрлэсэн хариуг цахимаар хүргүүлнэ. Уг дэд системийг Дэлхийн банк групп, Олон улсын санхүүгийн корпорацитай байгуулсан төслийн хүрээнд хийгдэнэ. Ухаалаг Засаг төслийн хүрээнд зөвхөн Нэг цэгийн үйлчилгээний төвийн системд холбох асуудал хамаарна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт, компанийн тоон мэдээлэл, татвар болон нийгмийн даатгал төлөлт, ажлын байрны тоо, гаалийн мэдээ, визийн мэдээ зэргийг компани тус бүр дээр болон нэгтгэсэн байдлаар сар бүр цахимаар цуглуулж, бодлого боловсруулахад ашиглана.

Төслийн нэгдсэн системийг сайжруулж, хөгжүүлэлт хийснээр Монгол Улсад хэрэгжих болон хэрэгжиж байгаа бүх төслийн мэдээлэлтэй танилцах, хөрөнгө оруулалт татах төслүүдийг нээлттэйгээр танилцуулж, сурталчилах, хөрөнгө оруулалт эрэлхийлсэн төслүүдэд бэлэн байдлын үнэлгээ хийж, бодит төслүүд танилцуулагдаж байна. Уг дэд систем эхний түвшинд хийгдсэн байгаа бөгөөд Ухаалаг Засаг төслийн хүрээнд үргэлжлүүлж хөгжүүлэлт хийх, нэгдсэн системд холбох ажил хийгдэнэ.

Нэгдсэн систем болон 4 дэд системээс бүрдсэн платформ байна. /тойм зургийг хавсралт 1-д хавсаргав/.

3. Ажлын зорилго болон хамрах хүрээ

Зөвлөх нь системийг загварчилж, дээр дурдагдасан дэд системүүд болон нэгдсэн систем хөгжүүлэх болон хэрэгжүүлэх ажлын даалгавар боловсруулна. Мөн зөвлөх нь хяналтын зөвлөх үйлчилгээ болон програм хүлээн авахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

Дараах нарийвчилсан ажлуудыг багтаасан байна. Үүнд:

3.1. Бизнес процессийг сайжруулах зураглал, техник хангамжийн болон програм хангамжийн нөхцлийг нарийвчлан заасан системийн болон техникийн шаардлагууд, архитектур дизайн, нэгдсэн болон дор дурдагдсан дэд системүүдийн шийдэл, болон өөрчлөлтийн менежментийн үйл ажиллагаануудыг агуулсан ажлын даалгаврын төсөл боловсруулах.

3.1.1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын компанийн бүртгэлтэй холбоотой үйлчилгээ, Гадаадын иргэн, харьяатын газрын виз, оршин суухтай холбоотой үйлчилгээ, Татвар болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын татвар, даатгалын үйлчилгээтэй холбоотой үйлчилгээнүүдийн өргөдлийг нэгтгэн цахим нэг өргөдөл болгох, төрд байгаа лавлагаа, мэдээлэл, тодорхойлолтыг байгууллага хоорондоо шууд солилцдог болгох систем хөгжүүлэлт.

3.1.2. Хөрөнгө оруулагчдын гомдлыг барагдуулах механизм /SIRM/ системийг нэгдсэн системтэй холбох шийдлийг тодорхойлж, ажлын даалгавар боловсруулах. Уг дэд систем нь дэлхийн банк групп, олон улсын санхүүгийн корпорацийн төслийн хүрээнд хийгдэх бөгөөд бэлтэл ажил хийгдэж байна.

3.1.3. Гадаадын шууд хөрөнгө оруулалт, компанийн тоон мэдээлэл, татвар болон нийгмийн даатгал төлөлт, ажлын байрны тоо, гаалийн мэдээ, визийн мэдээ зэргийг Монголбанк, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Гаалийн ерөнхий газруудаас компани тус бүр дээр болон нэгтгэсэн байдлаар сар бүр цахимаар цуглуулж, анализ хийдэг систем хөгжүүлэлт.

3.1.4. Одоо ашиглалтад орж байгаа Төслийн нэгдсэн системийг илүү сайжруулж, хөгжүүлэлт хийснээр Монгол Улсад хэрэгжих болон хэрэгжиж байгаа бүх төслийн мэдээлэлтэй танилцах, хөрөнгө оруулалт татах төслүүдийг нээлттэйгээр танилцуулж, сурталчилах, хөрөнгө оруулалт эрэлхийлсэн төслүүдэд бэлэн байдлын үнэлгээ хийх систем хөгжүүлэлт.

3.2. Нэг цэгийн үйлчилгээний цахим систем хөгжсөн орнуудын гурваас доошгүй судалгаа хийх, нэгээс доошгүй улсаас туршлага судлахад болон Монгол Улсад тохирсон хувилбарыг гаргахад дэмжлэг үзүүлэх.

3.3. Холбогдох төрийн байгууллагуудын системүүдийг холбох, мэдээлэл дамжуулах, мэдээлэл хайх, татах холболтыг хийхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, сервис дамжуулах хэлбэр, протоколыг тогтоох;

3.4. Систем хөгжүүлэлтийн явцын болон гүйцэтгэлд хяналт тавих, зөвлөгөө, удирдамжаар хангах.

3.5. Систем хүлээн авахад хяналт тавих, зөвлөх үйлчилгээ үзүүлэх.

4. Зөвлөхөд тавигдах шаардлага

Зөвлөх нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.1. Систем хөгжүүлэлт, систем хоорондын холболтыг оновчтой зохион байгуулах, архитектурыг мэргэжлийн өндөр түвшинд гаргаж байсан туршлагатай, энэ чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан байх.

4.2. Онлайн үйлчилгээ болон бизнес процессын оновчлол, бизнесийн мэдээллийн системийн удирдлага чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх.

4.3. Төсөл дээр мэдээллийн технологийн чиглэлээр 5-аас доошгүй жил ажиллаж байсан туршлагатай байх. Уг төслүүд нь олон улсын байгууллагын эсхүл олон улсын хэмжээний төслүүд бол давуу тал болно.

4.4. Мэдээллийн систем, мэдээллийн технологи, програм хангамжийн чиглэлээр болон эдгээртэй хамаарах чиглэлээр магистрын зэрэгтэй байх.

4.5. Бизнес процесс, ажлын дараалал, өгөгдлийн менежментийн чиглэлээр 5-аас дээш жил ажилласан туршлагатай байх.

4.6. Мэдээллийн системийн удирдлага, програм хангамжийн хөгжүүлэлтийн чиглэлээр 10-аас дээш жилийн ажлын туршлагатай байх.

4.7. Мэдээллийн системийн аюулгүй байдлын чиглэлээр мэргэшсэн, тухайн чиглэлээр 2-оос дээш жил ажилласан туршлагатай байх.

4.8. 5-аас дээш төсөлд систем хөгжүүлэлтийн явцын болон гүйцэтгэлд хяналт тавих, зөвлөгөө, удирдамжаар хангаж байсан туршлагатай байх.

4.9. Англи хэлний ярианы болон бичгийн өндөр мэдлэгтэй байх.

5. Ажиллах хугацаа болон байршил

Уг Ажлын даалгаварын 3.1, 3.2, 3.3-т заасан Зөвлөх үйлчилгээний ажлыг 3 сарын хугацаанд гүйцэтгүүлэхээр, 3.4-ийг цахим систем хөгжүүлэх хугацааны турш буюу 6 хүн-сарын хугацаанд, 3.5-г цахим систем хүлээн авах үед буюу 3 хүн-сарын хугацаанд гүйцэтгүүлэхээр төлөвлөж байна. Энэхүү зөвлөх үйлчилгээний ажил нь Улаанбаатар хотод хийж гүйцэтгэгдэнэ.

6. Үр дүн

Зөвлөх нь ажлын тайлангаа цаасан болон цахим хэлбэрээр дараах байдлаар бэлтгэж өгнө. Үүнд:

6.1. Эхлэлтийн тайлан: Ажил эхэлснээс хойш 14 хоногийн дотор монгол, англи хэлээр өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ, зөвлөхийн ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө, хүрэх үр дүнг тодорхойлж боловсруулан гаргаж өгнө.

6.2. Явцын тайлан: Ажил эхэлснээс хойш 45 хоногийн дотор монгол, англи хэлээр гол хүрсэн үр дүн, хийгдсэн ажлын тайлан, ажлын даалгаврын төслөө гаргаж өгнө.

6.3. Эхний шат /3.1-3.3/-ны эцсийн тайлан: Зөвлөх нь ажил үүргээ гүйцэтгэж дуусаад монгол, англи хэлээр ажлын тайлан болон “Гадаадын хөрөнгө оруулалтын “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн систем хөгжүүлэлтийн ажлын даалгавар”-ыг хүлээлгэн өгнө.

6.4. Гүйцэтгэлийн тайлан: цахим систем хөгжүүлэлтийн явцад сар тутам систем хөгжүүлэлтийн ажил Ажлын даалгаварын дагуу явагдаж байгаа эсэх тайланг гаргаж өгнө.

6.5. Хүлээн авах эцсийн тайлан: Цахим систем хүлээн авах үед систем хөгжүүлэлтийг бүрэн дууссан эсэх, хүлээн авах боломжтой эсэх тайланг гаргаж өгнө.

---oOo---

Annex-1


Investor
BIG SCREEN
Invest-Assist
OSS
SIRM
Statistic
Project Database
Linkage with Company's Registration number
DATA CENTER - KHUR
Registration office
Immigration
Tax office
Social insurance off
Ministries
Agencies
Local governments
Others
Bank of Mongolia
Registration office
Tax office
Social insurance off
Customs office
Immigration
Input statistic data every month